

СЭТГҮҮЛЧ Г.НАВААННАМЖИЛЫН НИЙТЛЭЛИЙН
ОНЦЛОГ, УР ЧАДВАР

Д.Өлзийбаяр*

* “Түгээмэл” дээд сургуулийн багш, хэл бичгийн ухааны доктор (Ph.D.), дэд профессор

Түлхүүр үг: Г.Навааннамжил, холбоо найруулал, цуврал найруулал, тэмдэглэсэн шүлэглэл, “Ардын эрх” сонин, намтарчилсан тууж.

Ардын хувьсгалын ялалтын дараа хуучин цагийн бичгийн чадвартай сэхээтэн нар хувьсгалт шинэ улсаа хөгжүүлэхэд хүчин зүтгэж эхэлсэн юм. Ийм хүмүүсийн нэг нь ахмад зохиолч, сэтгүүлч Галсангийн Навааннамжил байлаа. Зохиолч Г.Навааннамжил 1882 онд Халх Түшээт хан аймгийн Зоригт вангийн хошуу, одоогийн Төв аймгийн Өндөр ширээт сумын нутаг “Үүдэн цөл” хэмээх газар төржээ. Эцэг эх нь Навааннамжилыг 2 настайд нь садангийнхаа Галсан гэдэг хүнд үрчлүүлсэн байна. Галсан албатгүй хохь тайж байсан хийгээд, ан агнаж амьдардаг байжээ. Галсан, хүү Навааннамжилаа 10 нас хүрмэгц нь бичиг үсэгтэй хүн болгохын тулд нутгийн танил Ринчинд шавь оруулсан байна. Навааннамжил уйгагүй хичээл зүтгэл

гаргасны үр дүнд бичиг үсэгт шамдан суралцаж, хошуу тамгын тал бичээч болох эрх олж авав. Тэр удалгүй арван хэдэн насандаа сайн бичээч гэгдэж хошуу тамгын газар жинхэнэ бичээчээр дэвшин ажилласан байна. Ийнхүү алба хаахын зэрэгцээ манж, төвд зэрэг дорно дахины хэл бичигт суралцан эрдэмтэн мэргэдийн бичсэн, орчуулсан хуучин цагийн түүх намтрыг уншиж, мэдлэг боловсролоо дээшлүүлж байлаа.

Мөн аймаг, хошуудын доторх хашир сайн бичээч түшмэл гэгдсэн хүмүүсийн аймаг хошууныхаа ноёд дээдэстэй хийсэн элдэв заргын бичиг зохиолоос уншиж хуулан бичдэг байсан нь түүнд нийгмийн амьдралын зөрчлийг ойлгох чадвар суулган, улмаар улс төрийн үзэл бодол нь бүрэлдэн тогтоход зохих нөлөө үзүүлэв. Тэрээр хошуу тамганаас эхлээд Улиастай, Их хүрээ зэрэг олон газраар явж бичиг зохиолын алба хаасаар Ардын хувьсгалтай золгосон юм.

Навааннамжил ардын хувьсгал ялсны анхны өдрөөс эхлэн шинэ засгийн албанд зүтгэх болсон юм. Энэ тухайгаа "Миний бие их жанжин Сүхбаатар, Чойбалсан нартай удаа дараа учирч Ардын хувьсгалт төрд үүрд баттайгаар зүтгэн явах ариун зорилгоо амь биетэйгээ холбогдуулан илэрхийлсэнд хайрт хоёр удирдагч хүслий минь угтан авч халуунаар талархан итгэмжилж, засгийн газрын нарийн бичгийн даргаар авч ажиллуулав" гэж дурссан байдаг. Навааннамжил, МАХН-ын II их хуралд оролцож байсан ба 1924 оноос "Ардын эрх" сонины газар ажиллаж улмаар 1925 оноос "Үнэн" сонины эрхлэгчээр томилогдон ажилласан байна. Ийнхүү хэвлэлийн газар ажиллах болсон нь бичиж туурвих, боловсруулж найруулахын эрдэмд улам гүнзгийрүүлэн сургасан ажээ. Энэ үедээ тэр хэд хэдэн шүлэг бичсэний дээр "Баялгийг бадруулъя" (1924), "Эрдмийг бадруулъя" (1924), "Төр байж шашин тогтох нь үнэн бус хэмээнэ үү" (1925), "Хөдөөгийн байдал" (1927), "Улаан цэрэг ба Сүхбаатар" (1929) тэмдэглэл, нийтлэл бичиж хэвлүүлсэн нь хувьсгалт ололтоо бататган

хамгаалахад хүн ардын оюун санаанд нөлөөлөх нэгэн ёсны уриа байлаа. Мөн ийм сэдэвтэй цөөн хэдэн шүлэг ч бичжээ. 1927 онд зохиолч Г.Навааннамжил Октябрийн хувьсгалын 10 жилийн ойд оролцох төлөөлөгчдийг тэргүүлэн ЗХУ-д зочилж Москва, Ленинград зэрэг хотуудаар аялан явж коммунист намынхаа удирдлагаар шинэ амьдралаа

цогцлон байгуулж байгаатай танилцсан юм. Энэ тухайгаа "Лениний дурсгалын өдөр" (хураангуй тэмдэглэсэн шүлэглэл, 1929), "Нарны хотын мандал" ("Үнэн", 1928, №10) зэрэг зохиолдоо үзүүлсэн бөгөөд хожим бичсэн зарим томоохон

«
1929 оны 1-р сард хувьсгалын уран зохиолчдын анхны бүлгэмийг байгуулахад Навааннамжил оролцсон байна. Тэр 1942 онд Х.Чойбалсангийн амьдрал, үйл ажиллагааг харуулсан "Маршал Чойбалсангийн бага нас", малаа бэлчээрээр таргалуулсан Төв аймгийн сайн малчин Доржийн тухай "Хуучны сайн малчны ажиллагаа" зэрэг ном бичиж хэвлүүлжээ.

»

зохиолдоо дурсамж дурдатгалын хэлбэрээр ашигласан байна. 1929 оны 1-р сард хувьсгалын уран зохиолчдын анхны бүлгэмийг байгуулахад Навааннамжил оролцсон нь түүний бичих зохиох ажилд ихээхэн түлхэц болсон нь дамжиггүй юм. Хэдийгээр зарим үед өөр ажил хийж байсан боловч Навааннамжил сэтгүүлчийнхээ ажлыг орхиогүй юм. Тэр 1942 онд Монголын нам төрийг үндэслэгчийн нэг Х.Чойбалсангийн амьдрал, үйл ажиллагааг харуулсан "Маршал Чойбалсангийн бага нас", малаа бэлчээрээр таргалуулж, малдаа

шим сөл сайтай тэжээл бэлтгэн авдаг Төв аймгийн сайн малчин Доржийн тухай "Хуучны сайн малчны ажиллагаа" зэрэг ном бичиж хэвлүүлжээ.

Г.Навааннамжил амьдралынхаа сүүлийн 10 гаруй жилийг Шинжлэх ухааны хүрээлэнд ажиллан Монголын түүх, МАХН-ын түүхэнд холбогдолтой ном зохиолыг бичиж, архивын материалыг судлан нэгтгэх зэрэг эрдэм шинжилгээний ажил хийж байлаа. Тэр, Шинжлэх ухааны хүрээлэнгийн сурвалжлагч гишүүн, жинхэнэ гишүүнээр сонгогдон ажиллаж байжээ. Энэ бүхнээс үзэхэд Галсангийн Навааннамжил бол манай ахмад зохиолч, сэтгүүлч, шинжлэх ухааны зүтгэлтэн хүн юм. Энэ ахмад зохиолч, сэтгүүлч маань 1954 онд 72 настайдаа нас барсан ажээ.

Навааннамжил ерөнхий агуулга, хэлбэр байдлын талаас үзэхэд холбоо найрууллын шинжтэй "Бядан явагч бялзуухай" хэмээх цуврал найруулал, Монголын уран зохиол дахь намтарчилсан анхны тууж "Өвгөн бичээчийн өгүүлэл" зэрэг томоохон зохиолууд бичжээ. "Бядан явагч бялзуухай миний өгүүлэл" гэсэн найруулал тухайн үедээ зохиогчийн нэргүйгээр хэвлэгдэж байсан боловч Навааннамжилын зохиол гэдэг нь тодорхой байна. Анхны өгүүллийн оршилд "Бидний тусгайлсан нэр", "Улаан нүдэн", "Хөх намар" хэмээнэ гэж бичсэн хийгээд "Анваан, сонинд бага сага утга зохиол бичих ба мөн "Бядан явагч

бялзуухай" гэдэг зохиолыг гаргаж, энд тэндэхийн элдэв шүүмжлэлтэй ажлыг энэхүү бялзуухайгаас үзэж өгүүлсэн мэтээр найруулан зохиож бичихэд инээдтэй ичгүүртэй хэрэг их л бичигдэж, олны сонирхлыг татаж байв" гэсэн өөрийнх нь дурсамж зэрэг нь Навааннамжил энэ өгүүллийн зохиогч гэдгийг баталж байна. Харин нэгэн өгүүлэлд эх орны янз бүрийн өнцөг буланд болж байгаа хэсэг бусад үйл явдлыг өгүүлснээс үзэхэд тээврийн хэрэгсэл одоотой адил хөгжиж чадаагүй тухайн үед зохиогч энэ олон газраар нэгэн зэрэг орж чадахааргүй байсныг харгалзан үзвэл зарим өгүүллийг хөдөө орон нутгийн идэвхтэн бичигч нар бичиж ирүүлснийг Навааннамжил боловсруулан нийтэлдэг байсан байж болох юм. Гэлээ ч уран сайхнаар боловсруулсан байдал, хэл найруулгыг ажиглахад энэ нь Навааннамжилын бусад зохиолтой л их л төсөөтэй байна. "Бядан явагч бялзуухай миний өгүүлэл" цуврал найруулал нь сэдвийн хувьд олон янз байна.

Тэгэхдээ тухайн үеийн амьдралыг тусгахад голлон анхаарч байснаараа цаг үеийн асуудлыг хөндөж байжээ. Тэгэхдээ уран сайхныг нэлээд анхаарсан байна. Тухайлбал "Үнэнч хувьсгалч"-ийн тухай нэгэн найруулалд үйл явдлыг арьс шир хоёрын харилцан яриагаар гаргасан байна. Уг найруулалд Сонгино хайрхан уулын өвөрт салхинд хийсч явсан Арьс:

- Надад сонин зүйл их байна. Одоо бол шинэ цаг болж хуучин эзэрхэг ноёд, лам нар ба шинэ хуучин баячууд зэрэг ард олныг дарлаж байсан этгээдүүд одоо үед нам эвлэлийн гишүүн хувьсгалч сайн хүн болжээ гэхэд Шир:

- Би бас сонинг үзлээ. Миний явсан газар чоно, өмхий хүрэн, дорго мэт малд хортой этгээдийг арилган цэвэрлэхийн тул агнах явдал өргөнөөр явагдаж байна. Үүнд чоно мэт этгээдүүд сахил аваад хонь ямаа болоод явж байна гэхэд Арьс:

- Чоно мэт хортонгууд биеэрээ хонь, ямаа болоод явж тун болохгүй. Харин хонь ямааны арьс нөмөрсөн бус уу гэвэл Шир:

- Үгүй, тэр харгисууд биеэрээ хувьсгалч хүмүүс болж чадаагүй нь чоно мэт хортонгууд хонь ямаа болж чадаагүйн адил бус уу” гэж далд байдалд орсон хувьсгалын эсэргүү хуурам үзэлтэн нарын тухай их л далд утгаар ярилцаж байна. Үүний зэрэгцээ алив зүйлийг үлгэрийн хэлбэрээр шүүмжлэн илэрхийлж байв. Нэгэн найруулалд “Эрт балар цагт албан хэмээх оронд хойрго гэгч бий бүлгээ. Бас хүнд хэмээн газар сурталтан нэмээгчид бий бүлгээ. Тиймийн тулд албанаа хойрго буюу хүнд сурталтан хэмээх олонд алдаршсан ажээ. Тэдний байдал иймэрхүү:

- Хүүе хүүе чи босооч, яасан их унтдаг юм бэ? Явах цаг чиг болж байна гэхэд

- Ёо ёо босох юм уу даа хэмээжээ. Тэгж байтал цаг 9 хагас болно. Аажим алхсаар ийш тийшээ харж харж арай гэж 9 цаг 56 минутад яамандаа хүрнэ. Дараа нь өрөө тасалгаа хэсэж:

- Чи юу хийж байна. Миний хийх юм гэж жигтэйхэн их. Чи өчигдөр тэгэв үү, ингэв үү. Би тэгээд ингээд... гэх зэрэг огт албаны бус дэмий ярилцана.

Ингэж байтал цаг 11 болно. Арай гэж тасалгаандаа ирээд ажлаа хийх гэтэл тамхи татмаар санагдана. Дөнгөж тамхиа асаагаад байтал сайд орж ирээд,

- Та өчигдрийн миний даалгасан зүйлийг гүйцэтгэв үү. Үгүй, үгүй дарга минь, их юм хэцүү юм, тэгээд олдохгүй юм. Ингээд бүтэхгүй юм гэж” гэх зэргээр ажилдаа хойрго залхуу хүний тухай бичсэн байх ажээ. Бас зарим найруулалд бүр бодит баримттай зүйлийг хүртэл өгүүлж байв. Тухайлбал, нэгэн найруулалд Хэнтийн Улз хошууны шүүхийн байцаагч Цэрэндоржийн догшин ширүүн зан авирын талаар бичсэн байна. Харин энд зөвхөн үнэн хэрэг явдлыг бичсэн төдийгүй, уран дүрслэлийг ихэд эрхэмлэсэн нь зохиолыг уран сайхантай болгох эрэл хайгуул хийж байсныг гэрчилж байна. Тухайлбал Цэрэндоржтой уулзсан хүмүүс “арслан үзсэн гөрөөс мэт айна” гэж зүйрлэн үзүүлж, Цэрэндоржийн “Саатуулсан, овоолсон хэргүүд нь орон сууцандаа багтахгүй болж, саатан хүлээгчдийн сахал үс нь буурал

болоход хүрч байна” гэх зэргээр оновчтой уран хэтрүүлэл хэрэглэжээ.

Г Навааннамжил “Өвгөн бичээчийн өгүүлэл” гэдэг намтарчилсан зохиолдоо Манжийн ноёрхлын болон автономитын үеийн Монголын нийгэм эдийн засгийн байдал, хүмүүсийн амьдралын хир хэмжээ, хувьсгалаар эрх чөлөөгөө олж авсан Монголын ард түмний шинэ амьдралын түүхэн үнэнийг, түүхэн үйл явдлын он цагийн дэс дарааллыг хатуу баримтлан бичсэн байна. Ялангуяа нийгэм, цаг үеийн байдлыг өөрийн үзсэн харсантай холбогдуулан бичсэн нь түүхэн үнэний бодит гэрч болж байна. Тухайлбал банздуулж, шаахайдуулсан хүнийг харж айсан бяцхан Анваан “ийм хэцүү газар байснаас гэртээ харьж хонь хурга хариулах нь маш амгалан санагдаж явганаар гүйж” гэх зэргээр феодалын нийгмийн харгис хатуу хууль цаазыг уншигч олноо таниулж байна.

Нийгэм төрийн ийм бурангуй нөхцөлд Анваан хошуу тамгаас эхлээд Улиастай, Их хүрээ зэрэг газарт тал бичээчээс эхлээд туслах түшмэл хүртэл дэвшин ажиллажээ. Ийнхүү төрийн ажилд зохих хэмжээгээр зүтгэх болсон нь засаг төрийн бодлого мөн чанарыг ойлгож, нийгмийн амьдралын тэгш бус байдлыг үнэн зөвөөр мэдрэх болгосон юм. Энэ нь түүнийг улс төрийн чиг бодлого, өөрийн гэсэн үзэл санаатай хүн болгон хүмүүжүүлжээ.

Хуучин засгийн үед эрдэм боловсрол эзэмшсэн Анваан хувьсгалт үйлсэд шууд хүчин зүтгэж эхлэв. Тэр ардын хувьсгалын жилүүдэд туслах түшмэлээс Гадаад яамны дэд сайд, “Үнэн” сонины хариуцлагатай эрхлэгч зэрэг ажил хийн өөрийн авьяас билэг, хүч хөдөлмөрөө нам засагтаа өргөж байснаа “Өвгөн бичээчийн өгүүлэл” хэмээх дурсамж зохиолдоо тоочин өгүүлжээ. Анваан улмаар социализм коммунизмын ууган орон ЗХУ-д зочлон социалист байгуулалтын хөгжлийн шинэ төлөв байдлыг нүдээр үзэн сэтгэлээр танин бахархаж байна. Энэ бол хувьсгалаар эрх чөлөө олж авсан шинэ хүний нийгмийн эрх хичнээн өндөрт гарсныг илтгэж байна. Иймээс ч энэ зохиолын гол дүр нь зохиолч буюу Анваан билээ. Зохиолын бүхий л үйл явдал Анваантай салшгүй холбоотой дүрслэгдсэн тул нийгмийн хоёр өөр байгууллын үеийн эгэл хүний хувь заяа, үзэл санааны төлөвшил, өсөлт хөгжилтийг энэ ном үзүүлсэн онцлогтой байна.

Мөн манай ардын хувьсгалын их жолоодогч Д.Сүхбаатар, Х.Чойбалсан нар болон бусад ахмад хувьсгалчдын үйл хэрэг, үзэл санааны талаар нэлээд бичсэн нь уг номын дүр дүрслэлийг өргөн хүрээтэй болгосон байна. Тухайлбал, “Сүхбаатар зав чөлөөндөө улс орноо шинэ байдалд дэвшүүлэх, хувьсгалт цэргээ боловсронгуй цэргийн сургуулиар боловсруулах гэж өөрийн

биеэр өглөө үдэшгүй биечлэн байж, ямагт сургууль үйлдүүлэх, мөн цэргийн байр зэргийг ямагт эргэж, суух гэр, хүнс хэрэглэлийн сайн мууг мэдэж, дутуу мууг сайжруулж өгөх зэргээр оролдож байв” гэх зэргээр бичсэн нь Сүхбаатарын ажил хэрэгч, хүнлэг байдал аль алины нь тодруулж байна.

Мөн эсрэг дүрд Сью Шү-Жан, Барон Унгерн зэргийн үнэн байдлыг өгүүлсэн нь бас бий. Эдгээрээс гадна хээл хахуульд дуртай зусар түшмэл Юмжав, үнэнч шударга зантай захирагч Сүрэн зэрэг хувьсгалын эхэн үеийн албан тушаалтны байдал, сэтгэл са-

нааг үзүүлсэн дүрүүд цөөнгүй бий. Тэгэхдээ тэднийг хооронд нь нэлээд оновчтой ялгаруулсан байна. Тухайлбал Юмжав,

- Задарсан тархинууд энэ төрийн үед номхон шударгаар явахаа мэдэж байна уу? Шаахай хаян банз дэвтээ, “зарлагууд” гэж хашгиран хэрцгийлж байхад Сүндэв,

- Асар хүнд биш хэрэгтэй хүмүүсийг удтал тунтрагдаж амь биеийг осолдуулбал хууль ёсонд нийцэхгүй шүү гэж үнэн зөвийг учирлан хэлж байна.

Г.Навааннамжил “Өвгөн бичээчийн өгүүлэл” хэмээх энэ зохиолдоо өөрийн үзсэн түүхэн баримтат үйл явдлыг үзүүлэхдээ тухайн юмс үзэгдлийг уран сайхнаар дүрслэн үзүүлсэн нь нэн элбэг. Үүнд “Шар хар феодалууд айн бачимдаж мууранд хөөгдсөн хулгана мэт орох оронгүй болов...”, “...суух гэр нь үхэх сөнөх хүрээлэн мэт бодогдож”

гэх зэргээр урнаар зүйрлэн, гамингийн харгислал цагаанхаар солигдсон тухайд “Монголын ард түмэн чонын амнаас зайлж галзуу барсын аманд орсон мэт” гэж төлөөлүүлэн өгүүлсэн зэргээс үзэж болно.

Ийнхүү “Өвгөн бичээчийн өгүүлэл”

нь хувь хүний намтарт холбогдуулан улс орны нийгмийн байдал, хөгжил дэвшил тэргүүтнийг бичсэн баримтат зохиол юм. Гэхдээ уран сайхны хэрэглүүрийг ашигласны тухайд түүхэн найруулал, намтарчилсан туужийн шинжтэй юм. Гэвч энэ зохиолд ер нь Навааннамжилын нийт уран бүтээлд ямар нэгэн өчүүхэн бага зүйлийг ч гэсэн хэт дэлгэрүүлэн нурших, сунжруулах талын дутагдал үзэгдэнэ. Үүнийгээ өөрөө ч мэдэрч байсан юм. Тэр нэгэн зохиолдоо “20 гаруй жил үргэлжлэн ажилласан боловч бичгийг

«
Навааннамжил “Өвгөн бичээчийн өгүүлэл” гэдэг намтарчилсан зохиолдоо Манжийн ноёрхлын болон автономитын үеийн Монголын нийгэм эдийн засгийн байдал, хүмүүсийн амьдралын хир хэмжээ, хувьсгалаар эрх чөлөөгөө олж авсан Монголын ард түмний шинэ амьдралын түүхэн үзэнийг, түүхэн үйл явдлын он цагийн дэс дарааллыг хатуу баримтлан бичсэн байна.

»

товчлон, утгыг багтааж, нэр томьёо, дуу аялгуу, уран найруулга зэргийг бүрдүүлж чадсангүй” тал бий гэжээ.

Гэвч Галсангийн Навааннамжилын эдгээр бүтээл нь Монголын орчин үеийн баримтат зохиолын хөгжлийн эхэн үед хувь нэмрээ оруулсан бүтээлүүд болсон байна.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Навааннамжил Г.* 1953. Нэгэн бие гурван төр. УБ.
2. *Навааннамжил Г.* 1956. Өвгөн бичээчийн өгүүлэл. УБ.
3. *Норовсүрэн Л.* 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. УБ. Тэргүүн боть.
4. “Үнэн” сонин. 1928. № 30-31.
5. “Үнэн” сонин. 1929. № 5, № 51.
6. “Үнэн” № 35. № 39.

Резюме

В данной статье автор анализирует журналистскую деятельность Г.Навааннамжила, одного из пионеров монгольской журналистики. Г.Навааннамжил, в детстве получивший прекрасное образование, уже с первых дней победы Аратской революции посвятил себя служению для блага трудового народа. В 1924 году он стал работать в редакции газеты “Ардын эрх” (“Власть народа”), а в следующем году был назначен главным редактором газеты “Унэн” (“Правда”). В 1927 году он в составе монгольской делегации побывал в Москве и участвовал в праздновании 10-летия Октябрьской революции. Многогранно развитый Г.Навааннамжил также посвятил себя науке. В последние 10 лет своей жизни он работал в АН Монголии и избирался её членом-корреспондентом, действительным членом. Многие публикации Г.Навааннамжила по-праву вошли в сокровищницу отечественной публицистики. Его творчество занимает почётное место в иерархии монгольских литераторов и журналистов.